

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА



2018 он 10 сар 05 өдөр

“НЕОН ШОУ” ХХК-НЫ
ЗАХИРАЛ



2018 он 10 сар 04 өдөр

НИЙСЛЭЛИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
АЖЛЫН ХҮРЭЭНД “UB SPORT”-2018 БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ӨДӨРЛӨГИЙГ АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2018 оны 10 дугаар сарын 04

Улаанбаатар хот

№.....

Нэг талаас Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо (цаашид “Захиалагч” гэх)-ыг төлөөлж Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга А.Болдмаа нөгөө талаас “Неон шоу” ХХК менежер (“Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж Д.Бүдрагчаа нар энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ЗААЛТ

1.1. “Гүйцэтгэгч” нь Захиалагчийн захиалгын дагуу Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Ub Sport”-2018 биеийн тамир, спортын өдөрлөгийг арга хэмжээний тайз карказ, хөгжим, лед дэлгэц, асар, ширээ сандал, хулдаасан хэвлэлт түрээсээр нийлүүлнэ.

1.2. Захиалагч нь арга хэмжээний түрээсийн төлбөрийг гэрээний дагуу төлнө.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Түрээсийн хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.

2.2 Түрээсийн төлбөрийг түрээслүүлэгч байгууллагын Голомт банкны 1415101481 тоот дансанд шилжүүлнэ.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

3.1. Гэрээгээр гүйцэтгэх үйлчилгээний үнэ 5.630.000 (таван сая зургаан зуун гучин мянган) төгрөгийг төлнө.

3.2. Төлбөрийг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс өмнө төлнө.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Ub Sport”-2018 биеийн тамир, спортын өдөрлөгийг арга хэмжээний үеэр шаардлага хангасан тоног төхөөрөмж түрээслүүлэх

4.2. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал гомдлын шаардлага гаргах эрхтэй.

4.3. Гүйцэтгэгч ажил үйлчилгээг хийсний зардлыг саадгүй төлөх үүрэгтэй.

ТАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Гэрээнд заасан ажлыг биечлэн тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
5.2. Шаардлага хангаагүй тоног төхөөрөмж гарсан тохиолдолд засаж залруулах үүрэгтэй.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
6.2. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

ДОЛОО. БУСАД ЗААЛТ

- 7.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. (Эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)
7.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
7.3. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ

- 8.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
8.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

ЕС. НЭМЭЛТ НӨХЦӨЛ

.....
.....
.....

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИАЛАГЧ:

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ НБТХХ-
ЫН ДАРГА



А.БОЛДМАА

ГҮЙЦЭТГЭГЧ:

“НЕОН ШОУ” ХХК-НЫ
МЕНЕЖЕР

БҮДРАГЧАА

Д.БҮДРАГЧАА

НИЙСЛЭЛИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
 АЖЛЫН ХҮРЭЭНД "UB SPORT"-2018 БИЕИЙН ТАМИР,
 СПОРТЫН ӨДӨРЛӨГИЙГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЗ,
 КАРКАЗ, ХӨГЖИМ, САНДАЛ, ШИРЭЭ ХУЛДААСАН ХЭВЛЭЛ
 ХЭВЛЭЛ, ЛЕД, АСАР ТҮРЭЭСЛЭХ ҮНИЙН САНАЛ

2018 оны 10 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Хэмжээ, тоо ширхэг	Үнэ	Нийт үнэ
1	Тайз, краказ засах	7x4	2.000.000	2.000.000
2	Ширээ, сандал	55 ш	6000	330.000
3	Лед дэлгэц	6:4	800.000	800.000
4	Анонс чимэглэл: тайзны суурийн анонс тайзны анонс	7x4 4,5x1 5x5ш	500.000	500.000
5	Хөгжим үзелийн зардал	10 нүүр	600.000	600.000
6	Асар	10ш	140.000	1.400.000
Дүн				5.630.000

